



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 335

Улаанбаатар хот

“Эрчим инженеринг” ХХК-ийн нийтэд
санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийг
бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.9, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрчим инженеринг” ХХК-ийн нийтэд санал болгон гаргах 182 хоногийн хугацаатай, жилийн 18.50 %-ийн хүүтэй, нэг бүр нь 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 50,000 ширхэг “Эрчим бонд” өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-т үүрэг болгож, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/-д, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Өрийн хэрэгслийг нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэл арилжаанаас олсон орлогыг тусгаарлахыг “ҮЦТТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д үүрэг болгосугай.

3. Өрийн хэрэгслийн арилжааны тайланг анхдагч зах зээлийн арилжаа дууссанаас хойш ажлын гурав хоногт багтаан тус Хороонд ирүүлж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллахыг “Эрчим инженеринг” ХХК /Н.Баярмагнай/-д үүрэг болгосугай.

4. Өрийн хэрэгслийн борлуулалт, үндсэн болон хүүгийн эргэн төлөлтөд холбогдох журмын дагуу хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, “ҮЦТТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/, Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

5. Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөгдөх хугацааг үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссан өдрөөс тооцох ба үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд зохих төлбөрийг хөрөнгө оруулагчдад хугацаанд нь хийхийг “Соёмбо даатгал” ХХК /Ц.Баттулга/-д үүрэг болгосугай.

000967

6. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА